



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 269

Улаанбаатар хот

“Баянхайрхан” ХК-д “БИНСЭ” ХХК-ийг
нэгтгэх, компанийн оноосон нэрийг өөрчлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 8.2, 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Баянхайрхан” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 215,706 ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “БИНСЭ” ХХК-ийн хөрөнгөд ногдох нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,052,614 ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 1,268,320 ширхэг хувьцааг үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Баянхайрхан” ХК-ийн оноосон нэрийг “БИНСЭ” ХК болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Т.Жамбаажамц/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Баянхайрхан” ХК /Б.Батзаяа/-д үүрэг болгосугай:

1/ “Баянхайрхан” ХК-д “БИНСЭ” ХХК-ийг нэгтгэсэнтэй холбогдуулан хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөн байгуулах, “БИНСЭ” ХХК-ийн эзэмшилд байгаа хөрөнгийн эзэмших эрхийг “БИНСЭ” ХК-д шилжүүлэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх;

2/ Энэхүү тогтоолын 2-т заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

3/ Компанийн 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд гарсан өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

000270

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР
ХАМГААГАХ
Х.БУМ-ЭРДЭНЭ